



БҮРТГЭЛ, ХЯНАЛТ, ЗӨВЛӨГӨӨ

ДУНДМАНХАЙДАЙ  
АУДИТ ХХК

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Төмөрчний гудамж, Их найман шарга 10 давхар,  
Утас: 9908-5151, 9199-1462, Факс: (976-11) 32-52-62,  
E-mail: byambaahunnu@yahoo.com, http://www.dumaudit.mn

2024.05.21 № 43  
танай —ны № —т

“МЕРЕКС” ХК-ИЙН ТУЗ-ЫН ДАРГА  
Г.БЯМБАБАЯР, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРГИЙГ ТУР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

М.УНДРАЛ БОЛОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НАРТ

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

**Санхүүгийн Тайлангийн Аудитын Талаарх Тайлан**

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зерчлийг эс тооцвол “Мерекс” ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг матэриаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

Аудитаар “Мерекс” ХК -ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Аудитын гол асуудал**

Тус компани нь доорх гол асуудалд анхаарах шаардлагатай байна. Үүнд:

- Энэ нь нийт хөрөнгөөс өр төлберийн дүнг хасвал өөрийн хөрөнгийн дүн / 9,219,754,199.81 – 5,480,373,559.59/= 3,739,380540,22 төгрөг буюу хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн /6,500,500,000.00 төгрөг/-өөс (2.761.119.359.78) төгрөгөөр өөрийн хөрөнгийн төлберийн чадвар буурсан байна
- Санхүүгийн тайланд тусгасан Мөнхзолбоотой холбоотой 892,199.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл барагдаагүй, 182,949,165.11 төгрөгөөр буюу 24.0 хувиар төсөвт төлөх татварын өглөг өсөж, тооцоог барагдуулах үргээ биелүүлээгүй байна.
- Шүүхийн шийдвэртэй холбоотой 760,380.8 мянган төгрөгийн өр төлбөр шийдвэрлээгүй үлдэгдэлтэй;
- Улсын бүртгэлийн гэрчилгээнд компанийн дүрэм, гүйцэтгэх удирдлага болон эцсийн өмчлөгчийн шинэчлэл өөрчлөлтийг хийгээгүй;
- Компанийн харилцах данстыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн Албанаас битүүмжилсэн асуудал шийдээгүй ба Г. Манлайбаяр, М.Ундрал нарын ХААН банкны 5075433113,

5020836818 (MNT) харилцах дансаар гүйлгээ хийж буй нь харилцах дансны үлдэгдлийн баталгаажилт хангахгүй байна.

6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, еренхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1. жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 12.2.2. эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед; 12.2.3. эд хөрөнгө дутагдсан, эд хөрөнгийг хууль бусаар зарцуулсан байж болзошгүй гэж үзсэн үед; 12.2.5. аж ахуйн нэгж, байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай шийдвэр гарсан, дамжуурлын хэрэг үүсгэсэн үед; 12.2.6. хуульд заасан бусад тохиолдолд; гэсэн заалтууд хэрэгжээгүй тул үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг баталгаажуулах буюу залруулах боломжгүй байгаа нь тасралтгүй үйл ажиллагаанд эрсдэл учирч болзошгүй нь санхүүгийн тайлангийн "Тасралтгүй байх", "Иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Дээрх байдлын улмаас компанийн үйл ажиллагаа санхүүгийн тайланд хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.

#### **Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материалын алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоо юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

#### **Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага**

Залилан эсвэл алдаанаас үүссэн материалын буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитын ажлаар байгаа материалын буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материалын тооцогддог.

Бид засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй аудитын хамрах цар хүрээ, цаг хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сүл талуудын талаар компанийн ирүүлсэн баримт материалын хүрээнд илэрсэн дутагдал, зөрчлийн талаарх асуудлыг зөвлөмжээр удирдлагад танилцуулан хүргүүлсэн болно.

#### **Тайлангийн хэрэглээний хязгаарлалт**

Энэхүү аудиторын тайланг компанийн тухай хуулийн 94.1, 95.1 дүгээр зүйлүүдэд заасны дагуу компанийн удирдлага хувьцаа эзэмшигчдэд зориуулан бэлтгэсэн. Бид уг тайлангийн агуулгын хүрээнд аливаа нэг уравдлын этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хулээхгүй болно.

**ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК**

**УЛААНБААТАР ХОТ ЧД 2 ХОРОО**

Огноо: 2024.05.21